

**ХҮҮХЭД ХАРАХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ АНХНЫ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААРХ НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 12 дугаар
сарын 25-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх тухай асуудлыг Улсын Их Хурлын 2014 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж, төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооонд шилжүүлсэн билээ.

Хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Байнгын хорооны 2014 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 18 дугаар тогтоолоор хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатараар ахлуулан байгуулж, ажлын хэсэг төслийн талаар саналын томьёоллыг бэлтгэн, Байнгын хорооны хуралдаанд танилцуулж, санал хураалгав.

Төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхэд Улсын Их Хурлын гишүүн А.Бакей хуулийн төслийн нэр томьёог боловсронгуй болгох, гэр ашиглалтыг тодорхой болгох, Улсын Их Хурлын гишүүн Ё.Огтонбаяр хуулийн төсөл бодит хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх, хүүхдэд стандартын боловсрол олгох тухай асуудлыг тусгах, хүүхэд харах төвийн ажилтнуудын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, бизнесийн сүлжээ үүсэхээс урьдчилан сэргийлэх, хязгаарлах заалтыг оруулах, Улсын Их Хурлын гишүүн Д.Арвин аж ахуйн нэгж, албан байгууллагыг энэ үйлчилгээнд татан оролцуулах, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь цэцэрлэг байгуулахыг түлхүү дэмжих, хүүхэд харах үйлчилгээнээс гарах үр дагаврыг тооцох зэрэг саналыг гаргалаа.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай тус Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт, саналын томьёоллыг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



Д.БАТЦОГТ